

Мэргэжлийн үнэмлэх олгох журам

МОНГОЛ УЛС БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙДЫН ТУШААЛ

2000 оны 12 дугаар сарын 22-ны өдөр
хот

Дугаар 135

Улаанбаатар

Мэргэжлийн зөвлөл
байгуулах, журам батлах тухай

Соёлын тухай Монгол Улсын хуулийн 13 дугаар зүйлийн 1, 2 дугаар заалтыг үндэслэн
ТУШААХ нь:

1 Төв. Орон нутгийн мэргэжлийн урлагийн байгууллагад дагалдан жүжигчнээр ажиллаж,
мэргэжил эзэмшсэн жүжигчдэд "Мэргэжлийн үнэмлэх олгох зөвлөл" -ийн бүрэлдэхүүнийг
нэгдүгээр, "Мэргэжлийн үнэмлэх олгох журам"-ыг хоёрдугаар хавсралтын ёсоор тус тус
баталсугай.

2 Энэ тушаал гарсантай холбогдуулан "Мэргэжлийн үнэмлэх олгох тухай" Монгол улсын
Соёлын Сайдын 1995 оны 173 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай

САЙД

А.ЦАНЖИД

Сайдын 2000 оны 135 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

Мэргэжлийн үнэмлэх олгох зөвлөлийн бүрэлдэхүүн

Зөвлөлийн дарга : Соёл, урлагийн	- Боловсрол, соёл, шинжлэх ухааны Яамны бодлого, зохицуулалтын газрын дарга
Нарийн бичгийн дарга: Соёл, урлагийн бодлого, бодлого, зохицуулалт	- Боловсрол, соёл, шинжлэх ухааны Яамны зохицуулалтын газрын театр, дүрслэх урлагийн хариуцсан мэргэжилтэн
Гишүүд : найруулагч	- Сонгодог урлагийн академик театрын ерөнхий
найруулагч	- Улсын филармонийн уран сайхны удирдагч
найруулагч	- Үндэсний жүжгийн академик театрын ерөнхий
дарга / зөвшилцсөнөөр/ холбооны хорооны дарга /	- Улсын ардын дуу бүжгийн чуулгын ерөнхий - Монголын хөгжмийн зохиолчдын холбооны - Монголын Урлагийн Ажилтны Нийгэмлэгийн зөвшилцсөнөөр/

МЭРГЭЖЛИЙН ҮНЭМЛЭХ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийлэг үндэслэл

1,1 Төв., орон нутгийн мэргэжлийн урлагийн байгууллагад ажиллаж зохих түвшний дадал, мэргэжил эзэмшсэн дагалдан жүжигчдэд мэргэжлийн үнэмлэх олгоход энэхүү журмыг баримтална.

1,2 Мэргэлийн үнэмлэх олгох ажлыг улсын хэмжээнд мэргэжлийн үнэмлэх олгох зөвлөл / цаашид "зөвлөл" гэнэ/ хэрэгжүүлнэ. Зөвлөлийг соёлын асуудал эрхэлсэн сайдын тушаалаар байгуулна.

1,3 Орон нутагт мэргэжлийн салбар зөвлөл / цаашид "салбар зөвлөл" гэнэ/ ажиллна.

1,4 Мэргэжлийн үнэмлэх олгох ажлыг жилд хоёр удаа зохион байгуулна.

Хоёр. Мэргэжлийн салбар зөвлөлийн үйл ажиллагаа

2,1 Мэргэжлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг аймгийн Засаг даргын захирамжаар батлана. Зөвлөл нь 5-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй байна.

2,2 Салбар зөвлөлийн дарга нь тухайн аймгийн Засаг даргын тамгын газрын Ниймгийн хөгжлийн бодлогын хэлтсийн соёлын асуудал эрхэлсэн түшмэл байна.

2,3 Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд дараахь албан тушаалтан, уран бүтээлчдийг оролцуулна.

- Аймгийн боловсрол, соёлын төвийн соёлын асуудал хариуцсан арга зүйч
- Аймгийн театр, чуулгын дарга
- Таедр, чуулгын уран сайхны удирдагч
- Театр, чуулгын найруулагч
- Театр, чуулгын мэргэжлийн багш
- Театр, чуулгын уран сайхны зөвлөлийн ахмад уран бүтээлч

2,4 Салбар зөвлөл нь жилд 2 удаа мэргэжлийн үнэмлэх авах уран бүтээлчдээс дараахь чиглэлээр шалгалт авна.

А. Ерөнхий мэдлэг

Б. Мэргэжлийн онолын мэдлэг

В. Уран чадвар

Мэргэжлийн шалгалтын асуулга, тестийг салбар зөвлөлийн хурлаас тогтооно.

2,5 Мэргэжлийн шалгалтыг салбар зөвлөлийн гишүүдийн 70-аас доошгүй хувийн ирцтэй явуулна.

2,6 Салбар зөвлөл нь дараахь материалыг бүрдүүлэн мэргэжлийн үнэмлэх олгох зөвлөлд ирүүлнэ.

- Уран бүтээлчийн шалгалтын дүнгийн жагсаалт
- Уран бүтээлчдийн анкет, ажил байдлын тодорхойлолт
- Бүрэн дунд боловсролын үнэмлэхний хуулбар
- Иргэний үнэмлэхний хуулбар
- 3x4-ийн хэмжээний зураг 3ш
- Салбар зөвлөлийн дүгнэлт

Гурав. Мэргэжлийн шалгалтад ороход тавигдах шаардлага,

жүжигчний бүрдүүлэх материал

3,1 Мэргэжлийн шалгалтад орох уран бүтээлч дараахь шаардлагыг хангсан байна.

А. Мэргэжлийн шалгалтанд орох уран бүтээлч нь төв, орон нутгийн мэргэжлийн урлагийн байгууллагад 12-18 сар дагалдан жүжигчнээр ажилласан байна.

Б. Үнэмлэхний болон дэлхийн сонгодог бүтэнэлээс бие даан эзэмшсэн буюу мэргэжлийн түвшинд бэлтгэсэн баялаг урын сантай байна.

В. Тараас соёл, урлагийн салбарын хэмжээнд мөрдөж байгаа хууль, тогтоомж, журма, дүрэмтэй танилцаж зохих хэмжээний мэдлэгтэй болсон байна.

3,2 Шалгалтанд ороход дараахь материалыг бүрдүүлсэн байна.

- Уран бүтээлчийн өргөдөл,анкет
- Мэргэжлийн шалгалтад оруулах тухай байгууллагын тодорхойлолт
- Уран бүтээлийн жагсаалт
- Бүрэн дунд боловсролын үнэмлэхний хуулбар
- Иргэний үнэмлэхний хуулбар
- 3x4-ийн хэмжээний зураг 1 ширхэг

Дөрөв. Мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагаа

4,1 Зөвлөл нь 7-оос доошгүй хүний бүрэлдэхүүнтэй байна.

4,2 Зөвлөл нь салбар зөвлөлөөс ирүүлсэн материалыг хүлээн авснаас хойш 1 сарын дотор зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ.

4,3 Зөвлөлийн хурлын тэмдэглэл, дүгнэлтийг үндсэлэн соёлын асуудал эрхэлсэн сайдын тушаалаар мэргэжлийн үнэмлэх олгоно.